

ШУУРХАЙ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2019 оны 4 дүгээр сарын 8

№ 10

Дархан-Уул аймаг

Аймгийн Засаг даргын Шуурхай хурал 2019 оны 4 дүгээр сарын 8-ны өдрийн 08 цаг 30 минутад аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын зааланд хуралдав. Хуралдааныг аймгийн Засаг дарга С.Насанбат удирдаж, хуралд нийт 18 удирдах албан тушаалтнууд оролцохоос 17 оролцож хуралдааны ирц 94.4 хувьтай байв. Гишүүдийн ирцийн бүртгэлийг хавсаргав.

ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:

1.Хэлтэс, алба, сумдын дарга нарын өнгөрсөн 7 хоногийн ажлын тайлан, холбогдох шуурхай мэдээ, мэдээллийг танилцуулах, өмнөх шуурхай хурлаас өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийн талаарх мэдээ, тайланг танилцуулах.

Хуралд оролцсон хэлтэс, албад, сумдын дарга нар өнгөрсөн 7 хоногт хийсэн ажлын тайланг танилцуулав.

ҮҮРЭГ ДААЛГАВАР:

Санхүү, төрийн сангийн хэлтэс орлого биелүүлэх асуудлаар зөвлөлийн хуралд асуудал оруулах /СТСХ, ТХ/

СӨХ-ийн үйл ажиллагааны тайланг зөвлөлийн хуралд оруулах /ЗАА/

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын ажлыг эрчимжүүлэх /ХОХБТХ/

Ажил эрчимжүүлэх тухай үүрэг чиглэлийн дагуу уул уурхай олборлолтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, ААНэгжүүдийн үйл ажиллагаанд аймгийн ЗДТГ-ын ХОХБТХэлтэс, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Мэргэжлийн хяналтын газар, Цагдаагийн газрын хамтарсан хяналт шалгалтын ажлыг зохион байгуулах /ХОХБТХ/

Цаг үеийн мэдээллүүдийг шуурхай өгч байх. Арга хэмжээнүүдийн цагийн хуваарийг эртнээс мэдээлж хуваарьт оруулдаг болох. Тулгаж хэлэхгүй байхыг анхаарах /Бүгд/

Хурал 9 цаг 20 минутад дуусав

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТЭС